



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Сүхбаатар аймаг дахь төрийн
аудитын газар

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ НЬ МАЛЧДАД ЗУДЫН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН
ТУУЛАХАД БОДИТ ДЭМЖЛЭГ БОЛСОН БОЛОВЧ ХОРШООДЫН ҮЙЛ
АЖИЛЛАГАА ЖИГДРЭЭГҮЙ БАЙНА.

АУДИТЫН НЭР: “ШИНЭ ХОРШОО ХӨДӨЛГӨӨН”-д ОЛГОСОН ЗЭЭЛ, ЭРГЭН ТӨЛӨЛТ,
ҮР ДҮН

АУДИТЫН КОД: СБА-2026/21-16/ШТА-ГА

Баруун-Урт 2026 он



Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Г.Даваа

Утас: 70518396 Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Аудитын менежер М.Нарантуяа

Утас: 70512123 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор Н.Болдбаатар

Утас: 70512127 Цахим хаяг: oyunboldg@audit.gov.mn

Аудитор Э.Алтансүх

Утас: 70512127 Цахим хаяг: altansukhe@audit.gov.mn

Аудитор Б.Ганцэцэг

Утас: 70512127 Цахим хаяг: gantsetsegb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	4
БҮЛЭГ 1. СҮХБААТАР АЙМАГТ 706 ЗЭЭЛДЭГЧИД 24.4 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ХӨНГӨЛӨЛТЭЙ ЗЭЭЛ ОЛГОЖ, МАЛ АЖ АХУЙН САЛБАРТ ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛСЭН БАЙНА.	5
1.1. Хөнгөлөлттэй зээлээр мал аж ахуйн салбарт дэмжлэг үзүүлсэн боловч арга хэмжээний төлөвлөлт үр дүнд суурилаагүй байна.	5
1.1.1. Сүхбаатар аймагт "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ний хүрээнд 2024-2025 онд 265 хоршооны гишүүн малчин 706 зээлдэгчид 24.4 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож, мал аж ахуйн салбарт дэмжлэг үзүүлсэн байна.	5
1.1.2. "Шинэ хоршоо-чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөөнд туссан арга хэмжээний хүрэх түвшин, шаардагдах хөрөнгийг тодорхой тусгаагүй байна.	8
1.1.3. "Шинэ хоршоо-чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд орон нутагт 6 арга хэмжээ хэрэгжүүлж ажилласан байна.	9
БҮЛЭГ 2. ХОРШООДЫН САНГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ, ЗЭЭЛИЙН ХӨРӨНГӨӨР БИЙ БОЛГОСОН ЗАРИМ ХӨРӨНГИЙГ ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГАД БҮРТГҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.	10
2.1. Хоршоодын сангийн бүрдүүлэлт болон санхүүгийн тайлагналд тавих хяналт хангалтгүй байна.	10
2.1.1. Үүсгэн байгуулах гэрээг шаардахгүйгээр шинээр байгуулагдсан 240 хоршоог хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэсэн байна.	10
2.1.2. Хоршооны гишүүдийн хувь хөрөнгийн хэмжээг тусган баталж, улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн боловч 22 хоршооны хувьд санхүүгийн тайлангаас зөрүүтэй байна.	12
2.1.3. Хоршооны гишүүн малчны зээлд гишүүд нь хамрагдсан 265 хоршооны хувьд хоршооны хөгжлийн сан байгуулаагүй байна.	12
2.1.4. Борлуулалтын орлого 2025 онд тайлагнасан 39 хоршоо нь 342.1 сая төгрөгийг болзошгүй эрсдэлээс хамгаалах санд байршуулаагүй байна.	13
2.1.5. Хөнгөлөлттэй зээлд гишүүд нь хамрагдсан 265 хоршооны 32.0 хувь буюу 85 хоршоо нь санхүүгийн тайлан гаргаагүй байна.	15
2.2. Зээлийн эргэн төлөлт хэвийн байгаа боловч зээлийн санхүүжилтээр бий болгосон 26 худаг, 56 машин механизмыг эрх бүхий байгууллагад бүртгүүлээгүй байна.	16
2.2.1. "Хоршооны гишүүн малчны зээл"-ийг 706 иргэнд олгосноос гишүүн байх шаардлага хангаагүй 2 малчинд хөнгөлөлттэй зээл олгосон байна.	16
2.2.2. "Хоршооны гишүүн малчны зээл"-ийн эргэн төлөлт хуваарийн дагуу төлөгдөж байна.	18
2.2.3. Монголбанкны Сүхбаатар аймаг дахь салбар 36 зээлдэгчийн үйл ажиллагаанд, Зээлийн батлан даалтын сан 268 зээлдэгчийн үйл ажиллагаанд тус тус хяналт хэрэгжүүлсэн.	19
2.2.4. Сүхбаатар аймагт олгосон 24.4 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн 59.4 хувь буюу 14.5 тэрбум төгрөгийг "үржлийн мал бойжуулах, худалдан борлуулах" зориулалтаар зарцуулсан байна.	19
Холбогдох байгууллагын санал:	25
Ирүүлсэн саналд өгсөн тайлбар:	27
ДҮГНЭЛТ: 27	
ЗӨВЛӨМЖ:	28

Товчилсон үгийн тайлбар

ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БОГ	Байгаль орчны газар
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ЗБДС	Зээлийн батлан даалтын сан
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ТБОНӨҮГ	Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
УБГ	Улсын бүртгэлийн газар
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар

Хүснэгтийн жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн холбогдох заалтууд	5
2	Хоршооны гишүүн малчны зээлийн мэдээлэл, банкаар	6
3	Хоршооны гишүүн малчны зээл мэдээлэл, сумдаар	7
4	Хоршооны гишүүн малчинд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийн төлөвлөлт	8
5	"Шинэ хоршоо хөдөлгөөн"-ийг идэвхжүүлэх, сурталчлах үйл ажиллагааны хэрэгжилт	9
6	Хоршооны гишүүн малчны зээлийн олголт, зориулалтаар	17

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит үндэслэл, хийх бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2025 оны 25 дугаар тогтоолын дагуу хийв.
Аудитын зорилт	"Шинэ хоршоо хөдөлгөөн"-д олгосон зээл, эргэн төлөлт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан дүнг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг дарга, Монголбанк, ХААН банк, Төрийн банк болон бусад холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэнэ.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад ЗГ-ын 2024 оны 166 дугаар "Шинэ хоршоо хөдөлгөөн" өрнүүлэх тухай тогтоолоор "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөө баталсан. Тус төлөвлөгөөг хэрэгжүүлэгч байгууллагууд Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Монгол банк, ХХААГ, БОГ, ГХБХБГ, Хаан банк, Төрийн банкны аймаг дахь салбарууд мөн Аймгийн Засаг дарга болон Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 2024-2025 онд зээл авсан 265 хоршооны 706 малчдыг хамруулан аудитыг гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 3000, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт, MNS 6817-2020 "Төрийн аудитын стандарт", "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ыг ашиглан холбогдох байгууллагаас ирүүлсэн судалгаа, мэдээлэл, эрх бүхий байгууллагын хяналтын тайлан, цахим болон цаасан суурьтай нотлох баримтад үндэслэн асуудал хариуцсан албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, судалгаа мэдээллийг нягтлан шалгаж, нэгтгэх, харьцуулах, тооцоолох, дүн шинжилгээ хийх зэрэг горим, арга зүйг ашиглаж аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Г.Даваа удирдаж, аудитын менежер М.Нарантуяа чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Н.Болдбаатар, аудитор Э.Алтансүх, Б.Ганцэцэг нар 2026 оны 05 дугаар сарын 18-ны өдрөөс 6 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд аудитыг гүйцэтгэв.

БҮЛЭГ 1. СҮХБААТАР АЙМАГТ 706 ЗЭЭЛДЭГЧИД 24.4 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ХӨНГӨЛӨЛТЭЙ ЗЭЭЛ ОЛГОЖ, МАЛ АЖ АХУЙН САЛБАРТ ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛСЭН БАЙНА.

1.1. Хөнгөлөлттэй зээлээр мал аж ахуйн салбарт дэмжлэг үзүүлсэн боловч арга хэмжээний төлөвлөлт үр дүнд суурилагагүй байна.

1.1.1. Сүхбаатар аймагт "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ний хүрээнд 2024-2025 онд 265 хоршооны гишүүн малчин 706 зээлдэгчид 24.4 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож, мал аж ахуйн салбарт дэмжлэг үзүүлсэн байна.

1.1.1.1. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 сарын 24 өдөр "Шинэ хоршоо хөдөлгөөн" өрнүүлэх тухай 166 дугаар тогтоол батлагдсан байна. Тус тогтоол нь Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 6.1.2, 6.1.3, 6.1.4, 6.1.5, 6.1.6, 6.1.7-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолоор баталсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ын 4.2, 4.4-т заасныг хэрэгжүүлэх зорилгоор батлагджээ.

Хүснэгт 1. Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн холбогдох заалтууд

○	6.1.2.уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай мал аж ахуйн салбарыг тогтвортой хөгжүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, малчны амьжиргааг дэмжих арга хэмжээний төлөвлөгөөг батлах;
○	6.1.3.малчид нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор сайн дурын үндсэн дээр хамтрах, хоршоо байгуулах, малчдын хоршоонд элсэх санаачилгыг дэмжих;
○	6.1.4.мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх хүрээнд малчдын хоршооны хөрөнгө оруулалтад шаардагдах эх үүсвэрт дэмжлэг үзүүлэх;
○	6.1.5.байгалийн аюулт үзэгдэл, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин, цар тахлыг даван туулах, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг бууруулах, дасан зохицоход чиглэсэн мэдлэг, мэдээллийг малчдад олгох;
○	6.1.6.малчид харилцан суралцах, мэдлэг, туршлагаа хуваалцах, малчны залгамж халааг бэлтгэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх;
○	6.1.7.жилийн батлагдсан төсвийн нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсвийн ерөнхийлөн захирагч хооронд, хөрөнгийн болон урсгал зардал хооронд төсвийн зохицуулалт хийх.

1.1.1.2. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого" нь Монгол Улсын эдийн засгийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх, Коронавируст халдвар /КОВИД-19/-т цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлийг цаг алдалгүй шийдвэрлэж, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх, эдийн засаг, дэд бүтэц болон төрийн бүтээмжийг сайжруулахад чиглэсэн 10 хүртэлх жилийн хугацаанд хэрэгжих дунд хугацааны зорилтот хөтөлбөр байна.

1.1.1.3. "Шинэ сэргэлтийн бодлого"-ын 4.2-т шинэ суурьшлын бүс, дагуул хот, эдийн засгийн чөлөөт бүсийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан иргэн, аж ахуйн нэгжийг цогц бодлогоор дэмжих замаар төвлөрлийг сааруулахаар, 4.4-т эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн бодлогод тулгуурлан мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн тогтвортой өсөлтийг дэмжиж, хүнсний дотоодын хэрэгцээг хангахын зэрэгцээ экспортын хэмжээг нэмэгдүүлэхээр тус тус зорьжээ.

1.1.1.4. Бодлогын 4.2-т заасан төвлөрлийг сааруулах зорилтын хэрэгжилтийг хүн амын шилжилт хөдөлгөөний мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийхэд 2025 онд нийслэл болон бусад аймгаас Сүхбаатар аймагт 765 иргэн шилжин ирсэн бол 928 иргэн тус аймгаас нийслэл болон бусад аймагт шилжин явсан байна. Ингэснээр шилжин явсан иргэдийн тоо шилжин ирсэн иргэдийн тооноос 163-аар давж, аймгийн хүн ам шилжилт хөдөлгөөний нөлөөгөөр цэвэр дүнгээр 163 иргэнээр буурчээ.

1.1.1.5. Энэ нь Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэдийг цогц бодлогоор дэмжиж, төвлөрлийг сааруулах зорилтын үр нөлөө Сүхбаатар аймагт хангалттай түвшинд хүрээгүйг харуулж байна.

1.1.1.5. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 сарын 24 өдөр "Шинэ хоршоо хөдөлгөөн" өрнүүлэх тухай 166 дугаар тогтоолд "Шинэ сэргэлтийн бодлого"-ын Хот, хөдөөгийн сэргэлтийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан мал аж ахуйн салбарт үүсэж болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, мал аж ахуйн үйлдвэрлэл, малчдын хоршоог дэмжих замаар тогтвортой хөгжүүлэх зорилгоор "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий хүрээнд хэрэгжүүлэх 5 (тав) их наядын "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөөг баталж, 2 чиглэлийн хүрээнд 13 арга хэмжээ тусгасан байна.

1.1.1.6. Дээрх арга хэмжээний хүрээнд хоршооны гишүүн малчинд хөрөнгө оруулалтын зориулалтаар хөнгөлөлттэй зээл олгох арга хэмжээг зарим арилжааны банкуудтай хамтран зохион байгуулж 2024, 2025 онд улсын хэмжээнд нийт 894.8 тэрбум төгрөгийн зээл олгосноос Сүхбаатар аймагт 24.4 тэрбум төгрөгийн зээлийг 265 хоршооны гишүүн 706 малчинд олгосон байна.

Хүснэгт 2. Хоршооны гишүүн малчны зээлийн мэдээлэл, банкаар

(тэрбум төгрөгөөр)

№	Банкны нэр	Шийдвэрлэгдсэн			Үүнээс: Олгосон зээлийн дүн
		Хоршооны тоо	Малчны тоо	Шийдвэрлэсэн зээлийн дүн	
1	Хаан банк	96	225	7.5	7.5
2	Төрийн банк	169	481	16.9	16.9
Нийт		265	706	24.4	24.4

Эх сурвалж: Монгол банкны мэдээллийн сан

1.1.1.7. "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" арга хэмжээний хүрээнд хөнгөлөлттэй зээлд хамрагдсан малчдыг сумдаар ангилж, дараах хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 3. Хоршооны гишүүн малчны зээл мэдээлэл, сумдаар

(сая төгрөгөөр)

№	Сумын нэр	Шийдвэрлэгдсэн			Үүнээс: Олгосон зээлийн дүн
		Хоршооны тоо	Малчны тоо	Шийдвэрлэсэн зээлийн дүн	
1	Асгат	9	15	670.0	670.0
2	Баруун-Урт	84	197	6,865.3	6,865.3
3	Баяндэлгэр	15	47	1,254.0	1,254.0
4	Дарьганга	9	15	650.0	650.0
5	Мөнххаан	35	59	2,387.0	2,387.0
6	Наран	1	4	150.0	150.0
7	Онгон	6	20	645.0	645.0
8	Сүхбаатар	20	77	2,764.0	2,764.0
9	Түвшинширээ	5	34	993.0	993.0
10	Түмэнцогт	4	9	271.0	271.0
11	Уулбаян	12	33	1,235.0	1,235.0
12	Халзан	22	63	1,966.1	1,966.1
13	Эрдэнэцагаан	43	133	4,566.5	4,566.5
Нийт		265	706	24,416.8	24,416.8

Эх сурвалж: Монгол банкны мэдээллийн сан

1.1.1.8. Улсын хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар 247,950 малтай өрх байгаагаас 78.9 хувь буюу 195,526 өрх нь жилийн дөрвөн улирлын турш малаа маллаж, мал аж ахуйн үйлдвэрлэлийг амьжиргааны үндсэн эх үүсвэрээ болгосон малчин өрх байна. Эдгээр малчин өрхийн 13.5 хувьтай тэнцэх 26,437 малчин “Хоршооны гишүүн малчны зээл”-д хамрагджээ.

1.1.1.9. Сүхбаатар аймагт 2025 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр 8,966 малчин өрх бүртгэгдсэнээс 265 хоршооны гишүүн 706 малчин хөнгөлөлттэй зээлд хамрагдсан байна. Зээлдэгч малчдын тоог малчин өрхийн тоотой харьцуулахад 7.9 хувьтай тэнцэж байгаа бөгөөд энэ нь улсын дунджаас 5.6 нэгж хувиар бага байна.

1.1.1.10. Хоршооны гишүүн малчны зээлд гишүүд нь хамрагдсан 265 хоршооны гишүүдийн тоонд улсын бүртгэлийн байгууллагын мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийхэд 197 хоршоо 9 гишүүнтэй, 60 хоршоо 10-15 гишүүнтэй, 8 хоршоо 29-98 гишүүнтэй байна. Нийт хоршооны 97.0 хувь буюу 257 хоршоо нь 9-15 гишүүнтэй байгаа нь хоршоодын дийлэнх нь харьцангуй цөөн гишүүнтэй байгааг харуулж байна.

1.1.1.11. Харин хоршоо тус бүрээс зээлд хамрагдсан гишүүдийн тоог авч үзэхэд 88 хоршооноос нэг гишүүн, 71 хоршооноос хоёр гишүүн, 47 хоршооноос гурван гишүүн, 24 хоршооноос дөрвөн гишүүн, 35 хоршооноос 5-17 гишүүн тус тус зээл авсан байна.

1.1.1.12. Нэгээс хоёр гишүүн нь зээлд хамрагдсан 159 хоршоо нийт 265 хоршооны 60.0 хувийг эзэлж байна. Энэ нь хоршоодын дийлэнх нь 9-15 гишүүнтэй боловч хөнгөлөлттэй зээлийн үр өгөөж хоршооны нийт гишүүдэд хүртээмжтэй олгогдоогүй, цөөн тооны гишүүнд олгогдсон болохыг харуулж байна.

1.1.2. "Шинэ хоршоо-чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөөнд туссан арга хэмжээний хүрэх түвшин, шаардагдах хөрөнгийг тодорхой тусгаагүй байна.

1.1.2.1. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 сарын 24 өдөр "Шинэ хоршоо хөдөлгөөн" өрнүүлэх тухай 166 дугаар тогтоолоор "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий ач холбогдол, үр нөлөөг харьяа нутаг дэвсгэртээ сурталчлан таниулах, "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолтой уялдуулан зохион байгуулж, идэвхжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг, сум, багийн Засаг дарга нарт даалгаж, аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, багийн иргэдийн Нийтийн Хурлын дарга нарт зөвлөжээ.

1.1.2.3. "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ийг эхлүүлэх төв, орон нутгийн нэгдсэн арга хэмжээ, бүсийн уулзалт, хэлэлцүүлэг, сургагч багш бэлтгэх сургалт, сургагч багш нарын орон нутагт ажиллах томилолт, замын зардал, мэдээллийн нэг цэгийн үйлчилгээний (showroom) арга хэмжээнд шаардагдах зардлыг Монгол Улсын 2024 оны батлагдсан төсөвт зохицуулалт хийх замаар гүйцэтгэлээр тооцож санхүүжүүлэх талаар зааж өгсөн байна.

1.1.2.4. Мөн дээрх төлөвлөгөөний хүрээнд банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх хоршооны гишүүн малчинд 2029 он хүртэл олгох 5 хүртэл жилийн хугацаатай зээлийн 6 (зургаа) нэгж хувийн хүүгээс давсан хүүгийн төлбөрийг Монголбанкны бодлогын хүүтэй уялдуулан тооцож Засгийн газраас хариуцан төлөхөд Монгол Улсын 2024 оны батлагдсан төсөвт зохицуулалт хийх замаар, 2025-2033 онуудад шаардагдах эх үүсвэрийг тухайн жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахаар тусгажээ.

1.1.2.5. "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөө нь үйл ажиллагааны 2 чиглэлтэй байна. Тодруулбал "Хоршооны гишүүн малчинд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх"-үйл ажиллагааны хүрээнд 4 арга хэмжээ, "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ийг идэвхжүүлэх, сурталчлах үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх 9 арга хэмжээ төлөвлөсөн байна.

1.1.2.6. "Хоршооны гишүүн малчинд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх"-үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх 4 арга хэмжээний шалгуур үзүүлэлт, суурь ба хүрэх түвшин, санхүүжилтийн эх үүсвэрийн мэдээллийг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 4. Хоршооны гишүүн малчинд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийн төлөвлөлт

Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Санхүүжилтийн эх үүсвэр
1.1. Хоршооны гишүүн малчинд хөрөнгө	Малчдад олгосон зээлийн дүн	-	-	Банкны эх үүсвэр

оруулалтын зориулалтаар
хөнгөлөлттэй зээл олгох

1.2. Хоршооны гишүүн малчинд хөнгөлөлттэй хүүгийн зөрүүг хариуцах	олгосон зээлийн төрөөс	Хүүгийн зөрүүд олгосон дүн	-	-	Төсвийн зохицуулалтын эх үүсвэрээр
1.3. Малжуулах хөтөлбөрт хамруулах		Малжуулсан өрхийн тоо	1100 малчин өрх	2750 малчин өрх	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
1.4. Зээлийн батлан даалтын сангийн хөрөнгийг нэмэгдүүлж, нөөц санг бүрдүүлэх	өөрийн хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)		59,000.0	100,000.0	Төсвийн зохицуулалтын эх үүсвэрээр

Эх сурвалж: "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөө

1.1.2.7. Малчдад олгох зээлийн дүн болон хүүгийн зөрүүд олгох дүн гэсэн шалгуур үзүүлэлтүүдийн суурь ба хүрэх түвшин буюу шаардагдах хөрөнгийг "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөөнд тодорхой тусгаж өгөөгүй байна.

1.1.3. "Шинэ хоршоо-чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд орон нутагт 6 арга хэмжээ хэрэгжүүлж ажилласан байна.

1.1.3.1. "Шинэ хоршоо-чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ийг идэвхжүүлэх, сурталчлах үйл ажиллагааны 9 арга хэмжээний хэрэгжилтийн хувьд хамтран ажиллах байгууллагуудыг тодорхой тусгаж өгсөн байна. Тодруулбал аймгийн ЗДТГ-ын хувьд 6 арга хэмжээ, ХХААГ-ын хувьд 5 арга хэмжээ, сумын ЗДТГ-ууд 1 арга хэмжээг дээд шатны төр, захиргааны байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэхээр байна.

1.1.3.2. Төлөвлөгөөний дагуу Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар болон сумдын Засаг даргын Тамгын газруудаас "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ийг идэвхжүүлэх, сурталчлах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ, хүрсэн үр дүнг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 5. "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ийг идэвхжүүлэх, сурталчлах үйл ажиллагааны хэрэгжилт

Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ
2.1. Шинэ хоршоо хөдөлгөөнийг эхлүүлэх төв, орон нутгийн нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах	"Шинэ хоршоо" хөдөлгөөний нээлтийн арга хэмжээнд төрийн байгууллага, арилжааны банк, малчид, хоршоологчдын төлөөлөл бүхий 150 оролцогч хамрагдсан. Мөн улс, бүс, аймгийн түвшинд зохион байгуулсан 4 удаагийн арга хэмжээнд аймаг, сумдын хоршоодын 515 төлөөлөл, малчид, төрийн албан хаагчид оролцсон байна.
2.2. Шинэ хоршоо хөдөлгөөний бүсийн уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах	Зүүн бүсийн хоршоологчдын зөвлөгөөнд нийт 400 төлөөлөгч оролцсоноос тус аймгаас 80 малчин хамрагдсан. Зөвлөгөөний үеэр салбарын өнөөгийн байдал, хөдөлгөөний хэрэгжилтийн талаар мэдээлэл өгч, хоршоодын туршлага солилцох, тулгамдсан асуудлыг хэлэлцэх, хоршооны

	засаглал, бизнес төлөвлөгөө боловсруулах, төсөл бичих чиглэлээр сургалт зохион байгуулсан байна.
2.3. Орон нутагт ажиллах, малчдад зөвлөн туслах үүрэг бүхий сургагч багш нарыг бэлтгэх, сургалт зохион байгуулах	Хоршоо байгуулах чиглэлээр бүрэлдэхүүн ажлын хэсэг сумдын 13 мэргэжилтэн, сургагч багш нарын нийт 39 хүнийг сургалтад хамруулан бэлтгэж, орон нутагт ажиллах чиг үүргийг хэрэгжүүлсэн. Сургагч багш нар болон дэд ажлын хэсэг 2024 оны 05 дугаар сарын 10-наас 07 дугаар сарын 01-ний хугацаанд хамтран ажилласан байна.
2.4. Бэлтгэгдсэн сургагч багш нарыг орон нутагт ажиллуулж, малчдыг идэвхжүүлэх	Бэлтгэгдсэн сургагч багш нар малчин өрхүүдээр биечлэн явж, таниулга хийснээр 5,319 өрхийн 13,822 гишүүнд мэдээлэл хүргэсэн байна. Үүний үр дүнд аймгийн хэмжээнд 310 шинэ хоршоо шинээр байгуулагдаж, 2,800 малчин гишүүнээр элссэн байна.
2.8. 2024 оны хагас жилийн мал тооллогыг зохион байгуулах	2024 оны хагас жилийн мал тооллогыг тогтоосон хугацаанд зохион байгуулж, статистик мэдээллийн санг бүрдүүлсэн байна.
2.9. Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд газар олгох асуудлыг зохион байгуулах	Хоршоодод газар олгох ажлыг зохион байгуулах чиглэлээр сумдын Засаг дарга нарт чиглэл хүргүүлж, Сүхбаатар, Мөнххаан, Халзан, Дарьганга, Түвшинширээ сумдын нийт 53 хоршоонд 222.3 га газар олгосон. Түмэнцогт суманд 50 га газрын байршлыг тогтоосон шийдвэр гаргасан байна.

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн ЗДТГ

1.1.3.3. “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий салбар хоорондын уялдааг хангах Үндэсний хорооны 01 дүгээр тогтоолын дагуу Сүхбаатар аймагт хөдөлгөөнийг орон нутагт хэрэгжүүлэх ажлын хэсгийг байгуулж, батлагдсан төлөвлөгөөний арга хэмжээг зохион байгуулан ажилласан байна. Мөн аймгийн хэмжээнд хоршооллыг дэмжих бодлогын хүрээнд сүү боловсруулах үйлдвэр болон дундын хоршоо байгуулжээ.

1.1.3.4. Хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд хөдөлгөөний талаарх мэдээллийг 5,319 малчин өрхийн 13,822 гишүүнд хүргэж, 310 хоршоо шинээр байгуулагдан, 2,800 малчин хоршооны гишүүнээр элссэн бөгөөд 53 хоршоонд нийт 222.3 га газар олгосон байна. Энэ нь “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ийг орон нутагт сурталчлах, малчдыг хоршооны зохион байгуулалтад нэгтгэх чиглэлээр тодорхой үр дүн гарсныг харуулж байна.

БҮЛЭГ 2. ХОРШООДЫН САНГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ, ЗЭЭЛИЙН ХӨРӨНГӨӨР БИЙ БОЛГОСОН ЗАРИМ ХӨРӨНГИЙГ ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГАД БҮРТГҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

2.1. Хоршоодын сангийн бүрдүүлэлт болон санхүүгийн тайлагналд тавих хяналт хангалтгүй байна.

2.1.1. Үүсгэн байгуулах гэрээг шаардахгүйгээр шинээр байгуулагдсан 240 хоршоог хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэсэн байна.

2.1.1.1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д шинээр байгуулах хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгүүлэхэд бүрдүүлэх

баримт бичгийг тодорхойлсон бөгөөд 16.1.3-т хуулийн этгээд байгуулах шийдвэр /тогтоол/, дүрэм болон хуульд заасан тохиолдолд үүсгэн байгуулах гэрээг бүрдүүлэхээр заасан байна. Мөн "Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам"-ын 6.2.2-т шинээр байгуулсан хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөлд хуульд заасан тохиолдолд үүсгэн байгуулах гэрээг хавсаргахаар зохицуулжээ.

2.1.1.2. Хоршооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д хоршоог үүсгэн байгуулагчид хоршоо үүсгэн байгуулах талаар гэрээ байгуулж, уг гэрээнд хоршооны зорилго, үүсгэн байгуулагчдын оруулах хувь хөрөнгийн хэмжээ, эрх, үүрэг, хариуцлага зэргийг тусгахаар заасан байна. Мөн хуулийн 8.2-т хоршоог улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсгэн байгуулах гэрээ дуусгавар болохоор зохицуулжээ. Иймд үүсгэн байгуулах гэрээ нь хоршоог улсын бүртгэлд бүртгүүлэхээс өмнө заавал байгуулагдсан байх бөгөөд бүртгэлийн баримт бичгийн бүрдэлд хамаарахаар байна.

2.1.1.3. "Хоршооны гишүүн малчны зээл"-д гишүүд нь хамрагдсан 265 хоршооны үүсгэн байгуулагдсан хугацааг улсын бүртгэлийн мэдээлэлд үндэслэн авч үзэхэд 2024 оноос өмнө байгуулагдсан 25 хоршоо, зээлийн арга хэмжээ хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2024, 2025 онд шинээр байгуулагдсан 240 хоршоо байна.

2.1.1.4. Гэтэл Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтсээс дээд шатны байгууллагаас цахим хурлаар өгсөн чиглэлийн дагуу "Хоршооны гишүүн малчны зээл"-тэй холбоотойгоор шинээр байгуулагдсан хоршоодыг үүсгэн байгуулах гэрээ шаардахгүйгээр хялбаршуулсан хэлбэрээр улсын бүртгэлд бүртгэсэн талаар тайлбар ирүүлсэн байна.

2.1.1.5. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-д улсын бүртгэлд бүртгүүлэхээр ирүүлсэн баримт бичгийн бүрдэл дутуу бол бүртгэхээс татгалзахаар заасан. Түүнчлэн улсын бүртгэгч нь өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг нягталж, хууль, журамд заасан шаардлага хангасан тохиолдолд хүлээн авч, бүртгэх эсэхийг шийдвэрлэх үүрэгтэй байна.

2.1.1.6. Иймд хуульд заасан үүсгэн байгуулах гэрээг бүрдүүлээгүй хоршоодыг улсын бүртгэлд бүртгэсэн нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3, 18 дугаар зүйлийн 18.1.1, Хоршооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 болон "Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам"-ын 6.2.2-т заасан шаардлагад нийцээгүй байна.

2.1.1.7. Дээд шатны байгууллагаас цахим хурлаар өгсөн чиглэл нь хуульд заасан баримт бичгийн бүрдлийг өөрчлөх, эсхүл үүсгэн байгуулах гэрээг шаардахгүй байх эрх зүйн үндэслэл болохгүй юм. Үүний улмаас хоршоог үүсгэн байгуулагчдын оруулах хувь хөрөнгийн хэмжээ, эрх, үүрэг, хариуцлагыг харилцан тохиролцсон анхан шатны баримт бичиг бүрдээгүй, хоршооны гишүүдийн хооронд үүсэж болзошгүй маргаан болон хариуцлагыг шийдвэрлэх нотлох баримтын бүрдэл хангагдаагүй байна.

2.1.2. Хоршооны гишүүдийн хувь хөрөнгийн хэмжээг тусган баталж, улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн боловч 22 хоршооны хувьд санхүүгийн тайлангаас зөрүүтэй байна.

2.1.2.1. Хоршооны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.6–10.3.8-д хоршооны дүрэмд гишүүний оруулах хувь хөрөнгийн хэлбэр, түүнийг үнэлэх арга, гишүүний заавал оруулах хувь хөрөнгийн хэмжээ, хугацаа, заавал оруулах хувиас гадна хоршоонд нэмж оруулж болох хувь хөрөнгийн дээд хэмжээг тусгахаар зохицуулсан байна. Мөн хуулийн 15.2.3-т хоршооны гишүүний бүртгэлд гишүүнээс хоршоонд оруулсан хувь хөрөнгийн хэлбэр, хэмжээ болон гишүүнд хуваарилсан ногдох орлогыг тусгахаар заажээ.

2.1.2.2. Хоршоодын дүрэмд заасан нэг гишүүний заавал оруулах хувь хөрөнгийн хэмжээг авч үзэхэд 77 хоршоо буюу 29.1 хувь нь 50.0 мянган төгрөгөөс доош, 132 хоршоо буюу 49.8 хувь нь 50.0–100.0 мянган төгрөг, 56 хоршоо буюу 21.1 хувь нь 100.0 мянган төгрөгөөс дээш хэмжээгээр тогтоосон байна. Хоршооны гишүүн малчны зээлд гишүүд нь хамрагдсан 265 хоршоо улсын бүртгэлийн мэдээлэлд нийт 473.5 сая төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр бүртгэгдсэн байна.

2.1.2.3. Улсын бүртгэлийн мэдээлэлд тусгасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хоршоодын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн “Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө” дансны үлдэгдэлтэй тулган үзэхэд санхүүгийн тайлан гаргасан 181 хоршооноос 159 хоршоо буюу 87.8 хувьд зөрүүгүй, 22 хоршоо буюу 12.2 хувьд зөрүүтэй байна. Үлдсэн 84 хоршоо буюу нийт хоршоодын 31.7 хувь нь санхүүгийн тайлан гаргаагүй тул дээрх мэдээллийг тулган баталгаажуулах боломжгүй байв.

2.1.2.4. Зөрүүтэй байгаа 22 хоршооноос түүвэрлэж, нарийвчлан тулгалт хийхэд 2 хоршооны улсын бүртгэлд бүртгүүлсэн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь санхүүгийн тайлан дахь “Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө”-ийн үлдэгдлээс 12.1–78.0 сая төгрөгөөр бага, нэг хоршооны хувьд улсын бүртгэлд бүртгүүлсэн дүн нь санхүүгийн тайлангийн үлдэгдлээс 21.9 сая төгрөгөөр их байна.

2.1.2.5. Дээрх зөрүү нь гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн өөрчлөлт болон гишүүний хөдөлгөөнийг санхүүгийн бүртгэл, хоршооны гишүүний бүртгэл, улсын бүртгэлийн мэдээлэлд харилцан уялдаатай, тухай бүр шинэчлээгүй, эсхүл санхүүгийн тайланд хувь хөрөнгийг буруу бүртгэж, тайлагнаснаас үүссэн байх эрсдэлтэй байна. Иймд нягтлан бодох бүртгэлийн хяналтын улсын байцаагчид зөрүүтэй асуудлыг шилжүүлж, зөвлөмж хүргүүлээ.

2.1.3. Хоршооны гишүүн малчны зээлд гишүүд нь хамрагдсан 265 хоршооны хувьд хоршооны хөгжлийн сан байгуулаагүй байна.

2.1.3.1. Сангийн сайдын 2022 оны 8 дугаар сарын 01-ны өдрийн А/155 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хоршооны нягтлан бодох бүртгэлийн журам”-д “Хоршооны хөгжлийн сан гэж хоршооны хөгжил, хоршооны гишүүний нийгэм, эдийн засгийн байдлыг дээшлүүлэх, амьдралын чанар, амьдрах орчныг сайжруулах зорилгоор төвлөрүүлсэн тусгай зориулалттай санг хэлнэ” гэж заажээ.

Мөн тус журамд хоршооны хөгжлийн санд төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг банканд тусдаа данс нээж, байршуулна гэж зааж өгсөн байна.

2.1.3.2. Хоршооны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д "Хоршооны хөгжил, хоршооны гишүүний нийгэм, эдийн засгийн байдлыг дээшлүүлэх, амьдралын чанар, амьдрах орчныг сайжруулах зорилгоор хоршоо хөгжлийн сантай байж болно" гэж заажээ.

2.1.3.3. Хоршооны гишүүн малчны зээлд гишүүд нь хамрагдсан 265 хоршооноос санхүүгийн тайлан гаргасан 180 хоршооны 19 хоршоо нь санхүүгийн тайлангийн мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн тодруулга тайлангийн "Хоршооны хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгө" хэсэгт 29.7 сая төгрөгийг тайлагнасан байна. Эдгээр 19 хоршооны 18 хоршоо нь санхүүгийн Х тайлан гаргасан, 1 хоршоо нь 19.7 сая төгрөгийн борлуулалтын орлого тайлагнасан байна.

2.1.3.4. "Хоршооны хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгө"-ийн тодруулга тайлан нь үнэн зөв эсэхийг нягтлахад хоршооны хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгө бус тайлагналын алдаа байна. Тодруулбал санхүүгийн тайлан гаргасан хоршоодын санхүүгийн байдлын тайлангийн "Эздийн өмч"-ийн хэсэг дэх "Хоршооны хөгжлийн сан" мөрийн мэдээллийг шалгахад бүх хоршоо тэг төгрөгөөр тайлагнасан байна. Өөрөөр хэлбэл 265 хоршооноос "Хоршооны хөгжлийн сан" байгуулсан хоршоо байхгүй байна.

2.1.3.5. Хоршоод хөгжлийн сангаа бодитоор бүрдүүлсэн нь нотлогдохгүй, бүртгэл тайлагналын зөрүүтэй байгаагаас хоршооны санхүүгийн тогтвортой байдал, гишүүдийн хөрөнгийн хамгаалалт болон үйл ажиллагааны үр өгөөжид эрсдэл үүссэн байна.

2.1.3.6. Иймд 29.7 сая төгрөгийг "Хоршооны хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгө" гэж алдаатай тайлагнасан 19 хоршооны санхүүгийн тайланг холбогдох хоршоодоор залруулга хийлгэж, залруулгын хэрэгжилтэд хяналт тавих; цаашид хоршооны хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгө болон эх үүсвэрийн дүнг хянаж байх талаар санхүүгийн тайланг хянаж, хүлээн авах эрх бүхий байгууллага, албан хаагчид зөвлөмж хүргүүлэв.

2.1.4. Борлуулалтын орлого 2025 онд тайлагнасан 39 хоршоо нь 342.1 сая төгрөгийг болзошгүй эрсдэлээс хамгаалах санд байршуулаагүй байна.

2.1.4.1. Хоршооны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д "болзошгүй эрсдэлээс хамгаалах сан" гэж хоршоонд учирч болох эрсдэлээс хамгаалах зорилгоор тус хууль болон хоршооны дүрэмд заасны дагуу хоршооны борлуулалтын орлогоос хуримтлуулах мөнгөн хөрөнгийг ойлгохоор тодорхойлсон байна. Мөн хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т болзошгүй эрсдэлээс хамгаалах сангийн хөрөнгийг хоршооны санхүүгийн тогтвортой байдлыг хангах, алдагдлыг нөхөх, эрсдэлийг бууруулахад ашиглахаар, 25.3-т тус сангийн хөрөнгийг хөрөнгө оруулалтын зориулалтаар ашиглахыг хориглохоор тус тус зохицуулжээ.

2.1.4.2. Болзошгүй эрсдэлээс хамгаалах сан нь хоршооны ердийн үйл ажиллагаа, үндсэн хөрөнгө худалдан авах болон үйлдвэрлэлээ өргөтгөхөд зарцуулах хөрөнгө бус, харин үйл ажиллагааны алдагдал болон урьдчилан тооцоолоогүй эрсдэл үүссэн үед хоршооны төлбөрийн чадвар, санхүүгийн тогтвортой байдлыг хамгаалахад ашиглах тусгай зориулалттай эх үүсвэр байна.

2.1.4.3. Хоршооны тухай хуулийн 25.1.(Хоршооны тухайн жилийн борлуулалтын нийт орлогын 20 хүртэл хувийг болзошгүй эрсдэлээс хамгаалах санд хуваарилна.)-д гэж заасан бөгөөд мөн хуулийн 10.3.20 дахь заалтаар болзошгүй эрсдэлээс хамгаалах санд хуримтлуулах хөрөнгийн хувь хэмжээ, уг санд заавал байлгах хөрөнгийн хэмжээг хоршооны дүрэмд заавал тусгах зохицуулалттай байна.

2.1.4.4. Хоршооны гишүүн малчны зээлд гишүүд нь хамрагдсан Сүхбаатар аймгийн 265 хоршоо нь болзошгүй эрсдэлээс хамгаалах санд хуримтлуулах хөрөнгийн хувь хэмжээг борлуулалтын орлогын 2-20 хувь байхаар хоршооны дүрэмдээ тусгаж өгсөн байна.

2.1.4.5. "Хоршооны нягтлан бодох бүртгэлийн журам"-д болзошгүй эрсдэлээс хамгаалах санд хуваарилсан хөрөнгө буюу мөнгөн санг банканд тусдаа данс нээж, байршуулна гэж заасан байна.

2.1.4.5. Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсээс ирүүлсэн 2025 оны санхүүгийн тайлангийн мэдээллээр 24 хоршоо борлуулалтын орлого тайлагнасан байна. Харин Сүхбаатар аймгийн Татварын газраас ирүүлсэн 2025 оны аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангийн мэдээллээр 37 хоршоо борлуулалтын орлого тайлагнажээ. Эдгээр хоршоодын тайлагнасан борлуулалтын орлогын хэмжээ 55.0 мянган төгрөгөөс 1.5 тэрбум төгрөгийн хооронд байна.

2.1.4.6. Тайлангийн мэдээллийн давхардлыг арилгахад санхүүгийн болон татварын тайлангийн аль алинд борлуулалтын орлого тайлагнасан 22, санхүүгийн тайланд орлого тайлагнасан 2, татварын тайланд орлого тайлагнасан 15, нийт 39 хоршоо борлуулалтын орлого тайлагнасан байна.

2.1.4.7. Дээрх 39 хоршооны дүрэмд заасан болзошгүй эрсдэлээс хамгаалах санд хуваарилахаар тогтоосон хувь хэмжээг 2025 оны борлуулалтын орлогоос тооцож үзэхэд тус санд нийт 342.1 сая төгрөгийн хөрөнгө хуваарилахаар байна. Гэвч хоршоод уг хөрөнгийг болзошгүй эрсдэлээс хамгаалах санд хуваарилан нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, банканд тусдаа данс нээн байршуулаагүй байна.

2.1.4.8. Энэ нь Хоршооны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д "Хоршооны тухайн жилийн борлуулалтын нийт орлогын 20 хүртэл хувийг болзошгүй эрсдэлээс хамгаалах санд хуваарилна" гэж, Хоршооны нягтлан бодох бүртгэлийн журамд тус

санд хуваарилсан мөнгөн хөрөнгийг банканд тусдаа данс нээж байршуулахаар заасантай нийцэхгүй байна.

2.1.4.9. Хоршоод болзошгүй эрсдэлээс хамгаалах санг хууль болон дүрэмд заасан хэмжээгээр байгуулаагүйгээс санхүүгийн эрсдэл, алдагдал үүссэн үед түүнийг нөхөх эх үүсвэргүй болох, хоршооны санхүүгийн тогтвортой байдал алдагдах эрсдэлтэй байна. Мөн хоршооны удирдлага, бүх гишүүдийн хурлаас сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, хадгалалт, зарцуулалтад тавих дотоод хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

2.1.4.10. Борлуулалтын орлого тайлагнасан хоршоо тус бүрийн болзошгүй эрсдэлээс хамгаалах санд хуваарилах хөрөнгийн хэмжээг хоршооны дүрэмд заасан хувь хэмжээ болон борлуулалтын орлогын баталгаажуулсан дүнд үндэслэн дахин тооцож, санд хуваарилах хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусган, банканд тусдаа данс нээж байршуулах, санхүүгийн болон татварын тайланд тайлагнасан борлуулалтын орлогын зөрүүтэй хоршоодын мэдээллийг тулган баталгаажуулж, холбогдох тайланд залруулга хийлгэх асуудлыг нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагчид шилжүүлж, зөвлөмж өглөө.

2.1.5. Хөнгөлөлттэй зээлд гишүүд нь хамрагдсан 265 хоршооны 32.0 хувь буюу 85 хоршоо нь санхүүгийн тайлан гаргаагүй байна.

2.1.5.1. Гишүүд нь хөнгөлөлттэй зээлд хамрагдсан нийт 265 хоршооноос 181 хоршоо 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа гаргасан байна. Үүнээс 24 хоршоо нийт 1,761.5 сая төгрөгийн борлуулалтын орлого тайлагнасан бол 157 хоршоо үйл ажиллагаа явуулаагүй буюу "Х" тайлан ирүүлжээ. Харин 85 хоршоо санхүүгийн тайлангаа гаргаж, тайлагнаагүй байна. Өөрөөр хэлбэл борлуулалтын орлогогүй болон санхүүгийн тайлан гаргаагүй хоршоод дээрх 265 хоршооны 91.3 хувийг эзэлж байна.

2.1.5.2. Дээрх 85 хоршоо санхүүгийн тайлан гаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9.1, 10.5, 18.1, 18.3, 20.2.3, 20.2.12 дахь заалт, "Хоршооны нягтлан бодох бүртгэлийн журам"-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүрэг, хариуцлагыг хоршооны Тэргүүлэгчид хүлээнэ" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

2.1.5.3. ААНОАТ-ын тайлангийн мэдээллээс авч үзэхэд 57 хоршоо нийт 2,287.4 сая төгрөгийн борлуулалтын орлого тайлагнасан, 192 хоршоо үйл ажиллагаа явуулаагүй буюу "Х" тайлан гаргасан бол 16 хоршоо аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангаа гаргаж, тайлагнаагүй байна. Тодруулбал дээрх хоршоодын 86.0 хувь нь "Х" тайлан гаргасан болон ААНОАТ-ын тайлан гаргаагүй хоршоод байна.

2.1.5.4. "Хоршооны гишүүн малчны зээл"-д гишүүд нь хамрагдсан 265 хоршооноос 44 хоршоо нийгмийн даатгалын байгууллагад ажил олгогчоор бүртгэлтэй байна.

Үүнээс 29 хоршоо 2026 оны 5 дугаар сарын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан ирүүлсэн бол 15 хоршоо тайлан ирүүлээгүй байна.

2.1.5.5. Харин үлдсэн 221 хоршоо нийгмийн даатгалын байгууллагад ажил олгогчоор бүртгүүлээгүй байна. Нийт 265 хоршооны 89.1 хувь буюу 236 хоршоо 2026 оны 5 дугаар сарын нийгмийн даатгалын тайлан ирүүлээгүй бөгөөд үүний 221 нь ажил олгогчоор бүртгэлгүй, 15 нь бүртгэлтэй боловч тухайн сарын тайлангаа ирүүлээгүй байна.

2.1.5.6. Нийгмийн даатгалын байгууллагад ажил олгогчоор бүртгэлгүй, эсхүл бүртгэлтэй боловч тайлан ирүүлээгүй байгаа нь хоршоод тогтмол ажлын байр бий болгож, цалинтай ажилтан ажиллуулж байгаа эсэх нь тодорхойгүй, хөдөлмөр эрхлэлтийн бодит үр дүн хангалтгүй байгааг харуулж байна.

2.1.5.7. Хэрэв хоршоод хөдөлмөрийн гэрээгээр ажилтан ажиллуулсан боловч нийгмийн даатгалд бүртгүүлээгүй, шимтгэлийн тайлан гаргаагүй бол ажилтны тэтгэвэр, тэтгэмж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин болон бусад нийгмийн даатгалын хамгаалалтад хамрагдах эрх хөндөгдөх, шимтгэлийн өр төлбөр, алданги үүсэх, нөхөн тайлагнах болон хариуцлага хүлээх эрсдэлтэй байна.

2.1.5.8. Мөн ажилтан, цалин хөлсний мэдээллийг нийгмийн даатгал, татвар болон санхүүгийн тайланд харилцан уялдаатай тусгаагүй тохиолдолд хоршооны хөдөлмөрийн зардал, өр төлбөр, үйл ажиллагааны цар хүрээ бодитой илэрхийлэгдэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал алдагдах эрсдэлтэй.

2.1.5.9. Иймд нийт 265 хоршооны 89.1 хувь нь 2026 оны 5 дугаар сарын нийгмийн даатгалын тайлан ирүүлээгүй байгаа нь хоршоодын дийлэнх нь байнгын ажлын байр бий болгож, ажил олгогчийн хувиар тогтвортой үйл ажиллагаа явуулж эхлээгүй болохыг харуулж байна.

2.2. Зээлийн эргэн төлөлт хэвийн байгаа боловч зээлийн санхүүжилтээр бий болгосон 26 худаг, 56 машин механизмыг эрх бүхий байгууллагад бүртгүүлээгүй байна.

2.2.1. "Хоршооны гишүүн малчны зээл"-ийг 706 иргэнд олгосноос гишүүн байх шаардлага хангаагүй 2 малчинд хөнгөлөлттэй зээл олгосон байна.

2.2.1.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д "малчин" гэж мал аж ахуй эрхэлж, үндсэн орлогоо олдог иргэнийг ойлгохоор тодорхойлсон бөгөөд Малчны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т уг тодорхойлолтыг эш татан зохицуулсан байна. Энэхүү хуулийн шалгуурт үндэслэн "Хоршооны гишүүн малчны зээл"-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээний 3.1.1-д зээл хүсэгч нь хоршооны гишүүн малчин байх үндсэн шаардлагыг тусгажээ.

2.2.1.2. "Хоршооны гишүүн малчны зээл"-д хамрагдсан 706 иргэний зээл олгосон үеийн хөдөлмөр эрхлэлт, нийгмийн даатгалын мэдээллийг тулган шалгахад 22 иргэн буюу нийт зээлдэгчийн 3.1 хувь нь төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, уул уурхай, худалдаа, үйлчилгээний аж ахуйн нэгжид ажиллаж, нийгмийн даатгалын албан журмын даатгалд хамрагдаж байх хугацаандаа зээл авсан байна.

2.2.1.3. Нийгмийн даатгалын албан журмын даатгалд хамрагдсан байдал нь тухайн иргэнийг малчин биш гэж дангаар дүгнэх хангалттай үндэслэл болохгүй боловч түүний үндсэн орлогын эх үүсвэрийг нэмэлт баримтаар нягтлах шаардлагатай нөхцөл юм. Учир нь хуульд малчныг өөр ажил эрхэлдэггүй иргэн гэж бус, мал аж ахуй эрхэлж, үндсэн орлогоо олдог иргэн гэж тодорхойлсон байна. Мөн Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т малчнаас бусад мал өмчилж байгаа этгээдийг "мал бүхий этгээд" гэж тусад нь тодорхойлсон нь мал өмчилсөн иргэн бүрийг малчин гэж үзэхгүй байх эрх зүйн ялгааг тогтоожээ.

2.2.1.4. Дээрх иргэдэд зээл олгосон шалтгаан, нөхцөлийг нягтлахад санхүүжилтийн ерөнхий гэрээний 3.3-т гэрээний 3.1.1-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг улсын бүртгэлийн гэрчилгээ болон төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-Mongolia/-ийн "Малчны тодорхойлолт"-оор тодорхойлохоор тусгасан байна. Үүний дагуу арилжааны банкууд зээл хүсэгчдийн малчин байх шалгуурыг уг тодорхойлолтод үндэслэн хянаж, зээлийг шийдвэрлэжээ.

2.2.1.5. Гэвч өөр байгууллагад ажиллаж, нийгмийн даатгалын албан журмын даатгалд хамрагдаж байсан 22 иргэнд "Малчны тодорхойлолт" олгогдсон нь уг тодорхойлолт зээл хүсэгч мал аж ахуйгаас үндсэн орлогоо олдог эсэхийг бүрэн нотлоход хангалтгүй байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл "Малчны тодорхойлолт" нь тухайн иргэний малын бүртгэл болон мал аж ахуйтай холбоотой мэдээллийг баталгаажуулж болох боловч үндсэн орлогын эх үүсвэрийг дангаар тогтоох боломжгүй байна.

2.2.1.6. Санхүүжилтийн ерөнхий гэрээнд зээл хүсэгчийн үндсэн орлогын эх үүсвэрийг татвар, нийгмийн даатгал, хөдөлмөр эрхлэлт болон борлуулалтын орлогын мэдээлэлтэй тулган шалгах нэмэлт хяналтыг тусгаагүй, зөвхөн "Малчны тодорхойлолт"-д үндэслэхээр зохицуулсан нь мал өмчилдөг боловч мал аж ахуйгаас үндсэн орлогоо олдоггүй иргэн зорилтот бүлэгт зориулсан хөнгөлөлттэй зээлд хамрагдах эрсдэлийг бий болгосон байна.

2.2.1.7. Зээлд хамрагдсан 706 иргэний хоршооны гишүүнчлэлийн мэдээллийг улсын бүртгэлийн байгууллагын мэдээлэлтэй тулган шалгахад "Батбэх найрамдал хоршоо"-ны гишүүн гэж зээл авсан 2 иргэн тухайн хоршооны улсын бүртгэл дэх гишүүдийн мэдээлэлд бүртгэгдээгүй байна.

2.2.1.8. Хоршооны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6-д хоршоонд шинээр гишүүн элсүүлсэн тохиолдолд гишүүнээр элсүүлэх шийдвэр гарснаас хойш 90 хоногийн

дотор улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэхээр, мөн хуулийн 15.1, 15.2-т хоршооны гишүүний бүртгэлийг эрх бүхий бүртгэгч хөтөлж, гишүүнчлэлтэй холбоотой мэдээллийг бүртгэлд тусгахаар зохицуулсан байна.

2.2.1.9. Ийнхүү зээл хүсэгчийн малчин болон хоршооны гишүүн байх шалгуурыг мэдээллийн сангуудын уялдаа холбоо, үндсэн орлогын эх үүсвэр, гишүүнчлэлийг нотлох анхан шатны баримтаар бүрэн нягтлах хяналтын тогтолцоо бүрдээгүй байна. Үүний улмаас хөнгөлөлттэй зээл зорилтот бүлэгт бүрэн хүрэхгүй байх, шалгуур хангаагүй этгээд зээлийн дэмжлэгт хамрагдах, зээлийн эх үүсвэрийн хүртээмж буурах, төрөөс хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээний үр нөлөө алдагдах эрсдэл үүссэн байна.

2.2.2. "Хоршооны гишүүн малчны зээл"-ийн эргэн төлөлт хуваарийн дагуу төлөгдөж байна.

2.2.2.1. Зээлд хамрагдсан 706 иргэнд нийт 24,416.82 сая төгрөгийн зээл олгож, зээл авсан хугацаанаас хойш 2026 оны 3 дугаар сарын 31-ны өдрийг хүртэлх хугацаанд 4,539.24 сая төгрөгийн төлбөл зохих зээлийн дүнгээс 4,554.31 сая төгрөгийг (100.3%) эргүүлэн төлж, 20,288.19 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.

2.2.2.2. "Хоршооны гишүүн малчны зээл"-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээний 5.8 дахь заалтыг үндэслэн зээлдэгч тус бүрийн зээлийн эргэн төлөлтийн явц болон зээлийн төлөвт дүн шинжилгээ хийлээ. Тус заалтын дагуу зээлдэгч зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг дараалан 91-ээс дээш хоногоор хэтрүүлсэн тохиолдолд хүүгийн хөнгөлөлтийг зогсоох бөгөөд хэрэв зөрчлийг 191 хоногийн дотор арилгавал хөнгөлөлтийг нөхөн олгохоор зохицуулжээ.

2.2.1.3. "Хоршооны гишүүн малчны зээл"-д хамрагдсан нийт 706 зээлдэгчийн зээлийн эргэн төлөлтийн мэдээллийг арилжааны банкнуудаас гаргуулан авч үзэхэд 2026 оны I улирлын байдлаар хугацаа хэтэрсэн, анхаарал хандуулах шаардлагатай ангилалд 5 зээлдэгч бүртгэгдсэн байна. Харин 2026 оны 6 дугаар сарын байдлаар дээрх зээлдэгчид хугацаа хэтэрсэн төлбөрөө барагдуулж, нийт зээлдэгчийн зээл хэвийн ангилалд шилжсэн байна. Энэ нь аудитын хугацаанд зээлийн эргэн төлөлт хэвийн явагдаж, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлгүй болсныг харуулж байна.

2.2.2.4. Дээрх 5 зээлдэгчийн 3 нь ХААН банкнаас 14.5-23.0 сая төгрөгийн зээл авсан ба орон нутагт мал, малын түүхий эдийн үнэ ханш уналттай байснаас шалтгаалан орлого нь түр тасалдаж, зээлийн эргэн төлөлт нь 44-51 хоногоор хугацаа хэтэрсэн, 2 зээлдэгч нь Төрийн банкнаас 10.0-30.0 сая төгрөгийн зээл авсан бөгөөд Цагаан сарын баяр давхацсан болон бусад шалтгааны улмаас зээлийн эргэн төлөлт нь 28-76 хоногоор хугацаа хэтэрсэн байжээ.

2.2.2.5. Дээрх анхаарал хандуулах шаардлагатай 5 зээлдэгчийн хугацаа хэтрэлтийн хоног нь санхүүжилтийн ерөнхий гэрээний 5.8-д заасан хүүгийн хөнгөлөлтийг зогсоох үндэслэл болох 91 хоногийн хугацаанд хүрээгүй байна.

2.2.3. Монголбанкны Сүхбаатар аймаг дахь салбар 36 зээлдэгчийн үйл ажиллагаанд, Зээлийн батлан даалтын сан 268 зээлдэгчийн үйл ажиллагаанд тус тус хяналт хэрэгжүүлсэн.

2.2.3.1. “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээний 8.2 (Монголбанкны орон нутаг дахь нэгж “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн ашиглалт, зарцуулалтад зайны хяналт шалгалтыг хийнэ. Хяналт шалгалтыг хийхдээ холбогдох төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоос туслалцаа дэмжлэг авч болно.)-т заасны дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр баталсан удирдамжийн дагуу “Төрийн банк” ХК-д Таван их наяд хөтөлбөр (Шинэ хоршоо, малчны г.м)-д багадаа 20 зээлийн үйл ажиллагаанд, Сүхбаатар аймаг дахь Монголбанкны салбарын захирлын 2025 оны 11 дүгээр сарын 04-ны өдөр баталсан удирдамжийн дагуу ХААН банкны Сүхбаатар салбарт шалгалт хамрах хугацааны нийт зээлийн багцын 15-аас доошгүй хувьд хэсэгчилсэн шалгалтыг хийжээ.

2.2.3.2. Тус хяналт шалгалтаар Төрийн банкнаас хоршооны гишүүн малчны зээлд хамрагдсан 20 иргэний зээлийн зарцуулалтыг шалгахад 2 иргэний зээлийн зарцуулалтад мал, материал, тоног төхөөрөмж худалдсан иргэний данс руу шилжүүлэг хийсэн боловч худалдан авалтыг нотлох санхүүгийн анхан шатны баримт хангалтгүй тул тус 2 иргэний зээлд газар дээрх хяналтыг хийж, зээлийг зориулалтын дагуу ашигласан эсэхийг баталгаажуулахыг харилцааны менежер нарт анхааруулсан бол ХААН банкны Сүхбаатар салбараас хоршооны гишүүн малчны зээлд хамрагдсан 16 иргэний зээлийн зарцуулалтыг шалгахад зөрчил илрээгүй байна.

2.2.3.3. Сүхбаатар аймгийн хэмжээнд 295 хоршооны гишүүн малчны 8.9 тэрбум төгрөгийн зээлд 7.4 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан байна. “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээний 8.3 (Зээлийн батлан даалтын сан “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавина)-д заасны дагуу 2024, 2025 онд Сүхбаатар, Баяндэлгэр, Халзан, Баруун-Урт, Эрдэнэцагаан сумдын 93 хоршооны 268 малчин иргэний зээлийн 202-т нь зайны хяналт, 66-т нь газар дээрх хяналт мониторинг хийж ажилласан байна.

2.2.3.4. Мөн ХААН болон Төрийн банк “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээний 8.1 дэх заалтын хүрээнд 36 зээлдэгчийн үйл ажиллагаанд хяналт хийсэн нь нийт 706 зээлдэгчийн 5 хувийг эзэлж байх тул цаашид хяналт, шалгалтад хамруулах хувийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

2.2.4. Сүхбаатар аймагт олгосон 24.4 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн 59.4 хувь буюу 14.5 тэрбум төгрөгийг “үржлийн мал бойжуулах, худалдан борлуулах” зориулалтаар зарцуулсан байна.

2.2.4.1. “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээний 2.1.1-д “Мал худалдан авах, малын хашаа, хороо, саравч худалдан авах, шинээр барьж байгуулах, мал аж ахуйд зориулалттай барилга байгууламж барих, өргөтгөх,

засварлах, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл (автомашин) худалдан авах, шинэчлэх, дэд бүтцийг сайжруулах зэрэг хөрөнгө оруулалтын зээлийг дараах чиглэлүүдээр олгоно” гэж заажээ.

2.2.4.2. Сүхбаатар аймагт олгосон 24.4 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн 59.4 хувь буюу 14.5 тэрбум төгрөгийг “үржлийн мал бойжуулах, худалдан борлуулах” зориулалтаар зарцуулсан байна. Олгосон хөнгөлөлттэй зээлийн зориулалт, мөнгөн, зээлдэгчийн тоог дараах хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 6. Хоршооны гишүүн малчны зээлийн олголт, зориулалтаар

Зээлийн зориулалт	Мөнгөн дүн (сая төгрөг)	Зээлдэгч
Бэлчээрт худаг уст цэг гаргах усан хангамж байгуулах	537.70	14
Бүх төрлийн тэжээлийн ургамал тариалах тэжээлийн үйлдвэрлэл цех байгуулах өргөтгөх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	1,071.00	27
Мал бордох аж ахуй байгуулах өргөтгөх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	1,297.00	38
Мах сүү цагаан идээ бэлтгэх боловсруулах үйлдвэрлэл цех байгуулах өргөтгөх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	3,033.55	84
Үржлийн мал худалдан бойжуулах борлуулах	14,465.82	418
Ноос ноолуур арьс шир бэлтгэх анхан шатны тордолт хийх цэг цех байгуулах өргөтгөх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	47.00	1
Дотор мах боловсруулах үйлдвэр цех байгуулах өргөтгөх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	190.00	7
Мал малын гаралтай түүхий эдийн агуулах зоорь хөргүүр байгуулах	270.00	9
Мал төхөөрөх цех үйлдвэр байгуулах өргөтгөх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	540.00	18
Мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээ эрхлэх	416.00	13
Мал аж ахуйн үйлдвэрлэлд зориулагдсан малчдын хөдөлмөрийг хөнгөвчилсөн техник тоног төхөөрөмжийн дундын үйлчилгээ үзүүлэх технологи нэвтрүүлэх	872.75	26
ХАА-н гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийн зориулалттай барилга байгууламж барих өргөтгөх засварлах тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл автомашин тоног төхөөрөмж худалдан авах	1,676.00	51
Нийт дүн	24,416.82	706

Хоршоодын борлуулалтын орлого, ашиг, алдагдлын талаар

2.2.4.3. Гишүүд нь хөнгөлөлттэй зээлд хамрагдсан 265 хоршооны 37 хоршоо нийт 2.3 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого 2025 онд тайлагнасан, үүнээс 1 хоршоо ноолуурын худалдан авалттай холбоотой ажил гүйлгээг хоршооны дансаар дамжуулан зохион байгуулсантай холбоотойгоор 1.5 тэрбум төгрөгийн

борлуулалтын орлого тайлагнасан байна. Бусад хоршоодын хувьд 55.0 мянган төгрөгөөс 300.0 сая төгрөгийн борлуулалтын орлого тайлагнажээ. Эдгээр 37 хоршооны 25 хоршоо нь ашгийн татварт 5.7 сая төгрөг тайлагнаж, 12 хоршоо алдагдалтай ажилласан байна.

Ажлын байр, нийгмийн даатгалд хамрагдалтын талаар

2.2.4.4. Хоршооны гишүүн малчны зээлд хамрагдсан 706 зээлдэгчээс 3 хүн энгийн сайн дурын даатгалд, 80 хүн албан журмын даатгалд, 128 хүн малчны сайн дурын даатгалд 2026 оны 5 сарын байдлаар хамрагдаж байх бөгөөд 129 хүн тэтгэвэрт, 366 хүн нийгмийн даатгалд хамрагдаагүй байна. Албан журмын даатгалд хамрагдаж буй 80 хүнээс 6 хүн төсөл хэрэгжүүлэгч хоршооны нэр дээр нийгмийн даатгалд хамрагдаж байна.

2.2.4.5. Бусад 74 хүний хувьд уул уурхай, тээврийн компани, дэлгүүрийн үйл ажиллагаа эрхэлдэг компани, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, төрийн байгууллагуудад байнгын болон улирлын шинж чанартай ажил хийдэг байх бөгөөд 1 хүн төрийн захиргааны албан тушаалд ажилладаг, 1 хүн төрийн өмчит үйлдвэрийн газар байнгын орон тоон дээр ажиллаж байна. Эндээс үзэхэд 706 зээлдэгчээс 6 нь төсөл хэрэгжүүлэгч хоршооны нэр дээр албан журмын даатгалд хамрагдаж байна.

Хоршооны гишүүн малчны зээл ба малчны зээлийн талаар

2.2.4.6. Сүхбаатар аймагт 2023 оны жилийн эцэст 3,859.5 мянган мал тоологдсон бол 2024 онд 47.9 хувиар буюу 1,850.5 мянгаар буурч, жилийн эцэст 2,008.9 мал тоологдсон байна. Харин 2024 оны эхний хагас жилийн байдлаарх аймгийн малчны зээлийн дундаж үлдэгдлийг авч үзэхэд 68.0 орчим тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол 2025 оны жилийн эцэст малчны зээлийн үлдэгдэл 36.3 тэрбум төгрөгт хүрч, 53.4 хувиар буурчээ. Эндээс үзэхэд малчны зээлийн үлдэгдэл нь малын тоо толгойн бууралттай шууд хамааралтайгаар буюу ойролцоо хувиар буурсан байна.

2.2.4.7. Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд Сүхбаатар аймагт 2024 онд 19.8 тэрбум төгрөгийг 583 малчинд, 2025 онд 4.6 тэрбум төгрөгийг 123 малчинд, нийт 24.4 тэрбум төгрөгийн "Хоршооны гишүүн малчны зээл"-ийг 706 малчинд олгосон байна. Эдгээрээс дүгнэж үзэхэд "Хоршооны гишүүн малчны зээл" нь хөрөнгө оруулалтын зориулалттай зээл бөгөөд 2024, 2025 онд олгосон 24.4 тэрбум төгрөгийн зээл нь малчны зээлийн үлдэгдлийн бууралттай шууд холбоо хамаарал ажиглагдахгүй байна.

Малын худалдан авалтын талаар

2.2.4.8. Сүхбаатар аймгийн хэмжээнд "үржлийн мал бойжуулах, худалдан борлуулах зориулалтаар зээл авсан 418 зээлдэгчийн малын худалдан авсан ажил гүйлгээ нь малын А данстай уялдахгүй байх зөрчил нийтлэг байсан тул түүврээр 30 малчныг сонгон авч, улмаар худалдан авсан малын төрөл, тоог тухайн малчны А дансны мэдээлэлтэй нэг бүрчлэн тулган үзсэн.

2.2.4.9. Зээлийн санхүүжилтээр мал худалдан авсан 30 зээлдэгчийн зарцуулалтын баримтыг түүвэрлэн авч үзэхэд нийт 2,489 толгой адуу, үхэр, хонь, ямаа худалдан авсан тухай төлбөрийн баримт бүрдүүлж, худалдагчийн дансанд мөнгөн хөрөнгө шилжүүлсэн байна. Худалдан авсан малын тоог зээлдэгчдийн малын "А" дансны худалдан авсан малын мэдээлэлтэй тулган шалгахад 570 толгой мал буюу 22.9 хувь нь бүртгэлтэй тохирч, үлдсэн 1,919 толгой мал буюу 77.1 хувь нь мал тооллого, "А" дансны мэдээллээр баталгаажуулаагүй байна.

2.2.4.10. Ийнхүү мөнгөн шилжүүлэг хийсэн баримт байгаа боловч худалдан авсан малын дийлэнх нь малын бүртгэлд тусгагдаагүй байгаа нь зээлийн хөрөнгийг гэрээнд заасан зориулалтын дагуу бодитоор зарцуулсан эсэх, мал зээлдэгчийн өмчлөлд шилжсэн эсэхийг бүрэн нотлох боломжгүй болгож байна. Үүний улмаас зээлийн зориулалтын зарцуулалтад тавих хяналт сулрах, бодитоор хийгдээгүй худалдан авалтыг баримтаар бүрдүүлсэн байх, малын тоо толгой болон өмчлөгчийн мэдээлэл буруу бүртгэгдэх, зээлийн баталгаа болон эргэн төлөлтийн эх үүсвэр буурах эрсдэлтэй байна.

Машин, механизмын авто тээврийн бүртгэлийн талаар

2.2.4.11. "Хоршооны гишүүн малчны зээл"-ийн санхүүжилтээр 56 зээлдэгчийн худалдан авсан 54 трактор, 2 өөрөө явагч ачигч машин буюу нийт 56 техник хэрэгслийн бүртгэлийг Сүхбаатар аймгийн Автотээврийн төвийн мэдээллийн сантай тулган шалгахад холбогдох зээлдэгчдийн нэр дээр улсын бүртгэлд бүртгэгдээгүй, улсын бүртгэлийн дугаар болон тээврийн хэрэгслийн гэрчилгээ аваагүй байна.

2.2.4.12. Автотээврийн тухай хуулийн 17¹ дүгээр зүйлийн 17^{1.1}-д Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллага, иргэн тээврийн хэрэгсэл өмчилж авснаас хойш 72 цагийн дотор аймаг, нийслэл дэх автотээврийн асуудал эрхэлсэн байгууллагад бүртгүүлэхээр заасан байна. Мөн Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/222 дугаар тушаалаар баталсан "Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам"-ын 3.1, 3.2-т автотээврийн хэрэгслийг мэдээллийн санд шинээр бүртгэж, улсын бүртгэлийн дугаар, гэрчилгээ олгохоор, 12.1.6-д бүх төрлийн дугуйт болон гинжит трактор, өөрөө явагч машин механизмд хүнд машин, механизмын улсын бүртгэлийн дугаар олгохоор тус тус зохицуулжээ.

2.2.4.13. Иймд зээлээр худалдан авсан дээрх 54 трактор, 2 өөрөө явагч ачигч машиныг хуульд заасан хугацаанд улсын бүртгэлд бүртгүүлээгүй нь Автотээврийн тухай хуулийн 17^{1.1} болон "Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам"-ын холбогдох шаардлагад нийцээгүй байна.

2.2.4.14. Зээлийн санхүүжилтээр худалдан авсан техник хэрэгслийг зээлдэгчийн нэр дээр бүртгүүлж, гэрчилгээ, улсын дугаар авсан эсэхийг зээлийн зарцуулалтын дараах хяналтаар шалган баталгаажуулаагүй байна. Өөрөөр хэлбэл зээлдэгч, зээл олгосон банк болон арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих байгууллагууд хэрэгжилтийг нотлох баримтаар хянаагүй байна.

2.2.4.15. Түүнчлэн зээлийн хөрөнгөөр бий болсон техник хэрэгслийн байршил, ашиглалт, хадгалалт, өмчлөлийн шилжилт хөдөлгөөнийг бүртгэлд үндэслэн хянах боломж хязгаарлагдсанаар техник хэрэгслийг бусдад шилжүүлэх, худалдах, зориулалтын бусаар ашиглах, үрэгдүүлэх болон зээлийн эргэн төлөлтийг хангах хөрөнгийн эх үүсвэр буурах эрсдэлтэй байна. Иймд зээлийн хөрөнгөөр худалдан авсан бүртгэлд хамрагдах техник хэрэгслийг зээлдэгчийн нэр дээр хуульд заасан хугацаанд бүртгүүлэх, гэрчилгээ, улсын дугаар болон техникийн хяналтын үзлэгийн мэдээллийг зээлийн хувийн хэрэгт бүрдүүлэх, хэрэгжилтийг мэдээллийн сантай тулган хянах үйл ажиллагаа хангалтгүй байна.

Инженерийн хийцтэй гүний худгийн бүртгэлийн талаар

2.2.4.16. Сүхбаатар аймгийн Байгаль орчны газрын 2024–2026 онд олгосон худгийн зөвшөөрлийн дэлгэрэнгүй бүртгэлээс үзэхэд 31 хуулийн этгээд, 50 иргэнд 16 төрлийн зориулалтаар худаг гаргах болон ус ашиглахтай холбоотой зөвшөөрөл олгосон байна. “Хоршооны гишүүн малчны зээл”-д хамрагдсан 706 зээлдэгчээс 5 иргэн, зээлдэгчдийн гишүүнчлэл бүхий 265 хоршооноос 4 хоршоо тус бүр худгийн зөвшөөрөл авсан боловч эдгээр нь уг зээлийн санхүүжилтээр шинээр гаргасан худагтай хамааралгүй, бусад эх үүсвэрээр бий болгосон худаг байна.

2.2.4.17. Харин хоршоодын бизнес төлөвлөгөө, зээлийн зарцуулалтын баримт болон төлбөрийн гүйлгээг шалгахад 706 зээлдэгчээс 26 зээлдэгч зээлийн санхүүжилтээр гүний худаг шинээр гаргуулсан байна. Гэвч эдгээр 26 худаг Сүхбаатар аймгийн Байгаль орчны газрын худгийн бүртгэл, усны мэдээллийн санд бүртгэгдээгүй, худгийн паспорт олгогдоогүй байна.

2.2.4.18. Усны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3-т аймаг, нийслэлийн байгаль орчны алба ус хэрэглэгчийн худаг, цооногийг усны мэдээллийн санд бүртгэж, худгийн паспорт олгохоор, 27.4-т зөвшөөрөлгүйгээр цооног өрөмдөх, худаг гаргахыг хориглохоор тус тус заасан байна. Мөн хуулийн 28.6-д ус ашиглах зөвшөөрлийг хоногт ашиглах усны хэмжээнээс хамааран сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны алба, эсхүл сум, дүүргийн Засаг дарга олгож, усны мэдээллийн санд бүртгэхээр, 28.11-д холбогдох зөвшөөрөлд үндэслэн ус ашиглах эрхийн бичиг олгож, гэрээ байгуулснаар ус ашиглах эрх үүсэхээр зохицуулжээ. Ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглах, дур мэдэн цооног гаргахыг хуулийн 28.18-д хориглосон байна.

2.2.4.19. Ийнхүү зээлдэгчид зээлийн санхүүжилтээр гүний худаг гаргасны дараа хуульд заасан зөвшөөрөл, бүртгэл, паспорт болон ус ашиглах эрхийн баримт бичгийг бүрдүүлсэн эсэхэд арилжааны банк, орон нутгийн эрх бүхий байгууллагаас тавих дараах хяналт хангалтгүй хэрэгжсэн байна.

Газар олголтын талаар

2.2.4.20. Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд нэг удаа 5 га хүртэлх газар эзэмшүүлэх асуудлыг аймаг, сум, нийслэлийн Засаг дарга

дуудлага худалдаа, төсөл шалгаруулах зарчмаар шийдвэрлэх зохицуулалтыг Газрын тухай хуулийн 33.1.2-т зааж өгсөн байна.

2.2.4.21. Энэхүү хуулийн заалтын дагуу Сүхбаатар аймагт 2024, 2025 онд 53 хоршоонд “мал аж ахуйн үйлдвэрлэл, тэжээлийн ургамал тариалах” зориулалтаар 179.0 га, “мал аж ахуйн үйлдвэрлэл” зориулалтаар 43.2 га, нийт 222.3 га эзэмшлийн газрыг олгосон байна. Эзэмшлийн газар олгосон талбай хэмжээг авч үзэхэд 42 хоршоонд 5 га, 11 хоршоонд 0.2-4.97 га газар эзэмшүүлсэн байна.

2.2.4.22. Харин хоршооны гишүүд нь “Хоршооны гишүүн малчны зээл”-д хамрагдсан 265 хоршооноос 39 хоршоонд нийт 152.6 га газрыг эзэмшүүлсэн байна. Өөрөөр хэлбэл эдгээр 265 хоршооны 14.7 хувь нь Газрын тухай хуулийн 33.1.2-т заасан газрыг эзэмшжээ. Эзэмшүүлсэн газрыг зориулалтаар авч үзвэл “Мал аж ахуйн үйлдвэрлэл, тэжээлийн ургамал тариалах” зориулалтаар 114.0 га газрыг 23 хоршоонд, “Мал аж ахуйн үйлдвэрлэл” зориулалтаар 37.9 га газрыг 15 хоршоонд, “Эрчимжсэн мал аж ахуйн ферм” зориулалтаар 0.7 га газрыг 1 хоршоонд тус тус эзэмшүүлжээ.

2.2.4.23. Дээрх 265 хоршооны зээлд хамрагдсан гишүүдийн өмчлөлд 294 нэгж талбарын 25.9 га газар, эзэмшилд 158 нэгж талбарын 24.1 га газар, хоршооны нэр дээр 39 нэгж талбарын 152.6 га газар, нийт 491 нэгж талбарын өмчлөл, эзэмшлийн 202.6 га газар бүртгэлтэй байна. Харин зээл авсан малчид болон хоршооны аль нэг дээр өмчлөх, эзэмших газаргүй 60 хоршоо байна.

2.2.4.24. Малын хашаа саравч барих, тэжээлийн ургамал тариалах, хөргүүртэй агуулах, зоорь барих, мах боловсруулах цех барих зэрэг суурин барилга, байгууламж барих, өргөтгөх зориулалтаар зээл авсан 228 зээлдэгч байна. Эдгээрээс 69.3 хувь буюу 158 зээлдэгч нь өөрөө, эсхүл хоршооны нэр дээр эзэмшлийн газаргүй байна.

2.2.4.25. Тодруулбал малын хашаа саравч барих, өргөтгөх зориулалтаар 190 малчин зээл авсан боловч 129 нь эзэмшлийн газаргүй, тэжээлийн ургамал тариалах зориулалтаар 27 малчин зээл авсан боловч 21 нь эзэмшлийн газаргүй, мах боловсруулах цех барих зориулалтаар 7 малчин зээл авсан боловч эзэмшлийн газаргүй, хөргүүртэй агуулах, зоорь барих зориулалтаар 4 малчин зээл авсан боловч 1 нь эзэмшлийн газаргүй байна.

Холбогдох байгууллагын санал:



ХААН БАНК

ХХД-9007001013
СҮХБААТАР САЛБАР
Сүхбаатар аймаг, Баруун-Урт
сум, 7-р баг

Утас: 976-70518424
www.khanbank.com

2026 оны 07 дугаар
сарын 03-ны өдөр

Дугаар 5630/94/26

Баруун-Урт сум

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРЫН СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Тайлангын хариу, тодруулга хүргүүлэх тухай

Төрийн аудитын газраас Сүхбаатар аймагт "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ний хүрээнд малчдад олгосон хөнгөлөлтэй нөхцөлтэй зээлүүдэд хийсэн аудитын гүйцэтгэлийн тайлангийн "2.2.1 буюу "Хоршооны гишүүн малчны зээл"-ийг 706 иргэнд олгосноос малчны тодорхойлолтод нийцээгүй 22 иргэн, гишүүн байх шаардлага хангаагүй 2 малчинд хөнгөлөлттэй зээл олгосон байна" гэсэн дүгнэлтэд ХААН банкны зээл олгосон харилцагч байгаа эсэхийг тодруулж өгнө үү.

Тайлангийн дээрх заалтаас өөр нэмэлт тодруулга байхгүй болно.

САЛБАРЫН ЗАХИРАЛ



Г.БЯМБАТОГТОХ



ТӨРИЙН БАНК

СҮХБААТАР САЛБАР

22075, Сүхбаатар аймаг, Баруун-Урт сум, 7-р баг

Утас: 70518033, 70518034 Факс: (976-11) 319044

И-мэйл: s2700@statebank.mn

Вэбсайт: www.statebank.mn, Лавлах төв: 1800-1881

᠒᠐᠒᠖.᠐᠘.᠐᠑ № 44/᠑᠒3
Танай _____-ны № _____-т

**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Төрийн банкны Сүхбаатар салбар нь Үндэсний Аудитын газар, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд олгосон зээл, эргэн төлөлтийн үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлантай холбоотой санал хүсэлт байхгүй болно.

Хүндэтгэсэн,

САЛБАРЫН ЗАХИРАЛ



Б.СОНИНБАЯР

Ирүүлсэн саналд өгсөн тайлбар:

Шалгагдагч байгууллага болон аудитад хамрагдагч байгууллагуудад нэмэлт тайлбар, тодруулга байхгүй тул аудитын тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

Дүгнэлт:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий хүрээнд Сүхбаатар аймгийн 265 хоршооны гишүүн 706 зээлдэгчид нийт 24.4 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож, малчдын хөрөнгө оруулалтын санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлсэн байна. Аудитын хугацаанд зээлийн эргэн төлөлт хэвийн, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлгүй байгаа нь зээл олголт, эргэн төлөлтийн түвшинд эерэг үр дүн гарсныг харуулж байна.
2. Гэвч уг арга хэмжээний зорилго нь зөвхөн иргэн бүрд зээл олгохоос гадна малчдыг хоршооны зохион байгуулалтад нэгтгэх, хамтын үйлдвэрлэл, борлуулалтыг хөгжүүлэх, орлого, ажлын байр, санхүүгийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн байна. Төлөвлөгөөнд эдгээр үр дүнг хэмжих суурь болон хүрэх түвшин, мэдээллийн эх үүсвэр, хариуцах байгууллага, тайлагнах хугацааг бүрэн тодорхойлоогүйгээс арга хэмжээний бодит үр нөлөөг хэмжих нөхцөл бүрдээгүй байна.
3. Хоршоодын үйл ажиллагааны үр дүнг авч үзэхэд нийт 265 хоршооны 39 буюу 14.7 хувь нь борлуулалтын орлого тайлагнасан бөгөөд хоршоодын 60.0 хувьд зөвхөн 1–2 гишүүн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан байна. Мөн 85 хоршоо санхүүгийн, 16 хоршоо татварын, 236 хоршоо нийгмийн даатгалын тайлан ирүүлээгүй байгаа нь хоршоодын дийлэнх хэсгийн бодит үйл ажиллагаа, орлого, ажлын байр болон гишүүдэд бий болгосон үр өгөөжийг тайлангийн мэдээллээр баталгаажуулах боломжгүй болгожээ.
4. Хоршооны хөгжлийн санг бодитоор байгуулж, нягтлан бодох бүртгэлд тусгасан нь нотлогдоогүй бөгөөд борлуулалтын орлого тайлагнасан 39 хоршоо дүрэмд заасан хувь хэмжээгээр нийт 342.1 сая төгрөгийг болзошгүй эрсдэлээс хамгаалах санд хуваарилаагүй байна. Үүний улмаас хоршоод үйл ажиллагааны алдагдал болон санхүүгийн эрсдэлийг дотоод эх үүсвэрээр нөхөх, үйлдвэрлэлээ тогтвортой үргэлжлүүлэх санхүүгийн чадавх бүрдээгүй байна.
5. Зээл хүсэгчийн шалгуур болон зээлийн зориулалтын зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байжээ. Тухайлбал, 22 зээлдэгчийн мал аж ахуйгаас үндсэн орлогоо олдог эсэхийг нэмэлт мэдээллээр баталгаажуулаагүй, 2 зээлдэгчийн хоршооны гишүүнчлэл бүртгэлийн мэдээллээр нотлогдоогүй байна. Мал худалдан авсан 30 зээлдэгчийн түүвэр шалгалтаар 2,489 толгой малын 77.1 хувь буюу 1,919 толгой малын худалдан авалт малын "А" дансны мэдээллээр баталгаажаагүй байна.

6. Зээлийн хөрөнгөөр шинээр гаргасан 26 худаг усны мэдээллийн санд бүртгэгдэж, худгийн паспорт болон ус ашиглах эрхийн баримтаар баталгаажуагүй, худалдан авсан 54 трактор, 2 өөрөө явагч ачигч машин зээлдэгчдийн нэр дээр улсын бүртгэлд бүртгэгдээгүй байна. Мөн суурин хөрөнгө оруулалт, тариалангийн зориулалтаар зээл авсан 228 зээлдэгчийн 158 нь өөрийн болон хоршооны нэр дээр газар эзэмших эрхгүй байгаа нь бизнес төлөвлөгөөнд тусгасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх зүйн болон материаллаг нөхцөл бүрдээгүйг харуулж байна.
7. Зээлийн зарцуулалт, төслийн хэрэгжилт, хөрөнгийн бүртгэл, хоршооны үйл ажиллагааны үр дүнг зээл олгохоос өмнөх, хэрэгжилтийн үеийн болон дараах үе шатанд уялдуулан хянах нэгдсэн тогтолцоо бүрдээгүй байна. Монголбанк, арилжааны банк, Зээлийн батлан даалтын сан болон орон нутгийн байгууллагууд тус тусдаа хяналт хийсэн боловч хяналтын хамрах хүрээ, үр дүнг нэгтгэж, илэрсэн асуудлыг бүрэн арилгуулаагүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитаар өгсөн дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэст:

1. Үйл ажиллагаа нь жигдрээгүй, сургалт, мэдээлэл шаардлагатай хоршоодод ХХААГ болон холбогдох байгууллагуудтай хамтран мэргэжил, арга зүйн зөвлөгөө, сургалт, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулж ажиллах.

Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст:

2. Санхүүгийн тайлан мэдээг хуулийн хугацаанд тайлагнаагүй 85 хоршоонд хууль, журмын дагуу арга хэмжээ авч, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, мөн хоршооны хөгжлийн сан болон болзошгүй эрсдэлээс хамгаалах сангийн нягтлан бодох бүртгэл, тайлагналд хяналт тавьж ажиллах.

Сүхбаатар аймгийн Татварын газарт:

3. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангаа гаргаж, ирүүлээгүй 16 хоршооны татварын тайлагналын асуудлыг нягтлан, татварын үүрэг үүссэн хоршоодоор тайланг нөхөн гаргуулж, хуульд заасан арга хэмжээ авах.

Сүхбаатар аймгийн Байгаль орчны газарт:

4. Хоршооны гишүүн малчны зээлийн хөрөнгөөр шинээр гаргуулсан 26 худгийн зөвшөөрлийн бүртгэлийг нөхөн хийлгэх ажлыг зохион байгуулах, худгийн зөвшөөрлийн сан болон худаг, усан сангийн бүртгэл, тооллогод хамруулах.

Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст:

5. Цаашид хоршоо шинээр бүртгэхэд хуульд заасан баримтын бүрдлийг шалгах хяналтын хуудас ашиглаж, бүрдэл дутуу өргөдлийг бүртгэхгүй байх.
6. Хоршооны гишүүнчлэл нь бүртгэлээр баталгаажаагүй 2 зээлдэгчийн гишүүнээр элсүүлсэн шийдвэр, гишүүний бүртгэл, хувь хөрөнгө оруулсан баримтыг нягтлан, бүртгэлийн мэдээллийг хуульд нийцүүлэн шийдвэрлэх.

Сүхбаатар аймгийн Автотээврийн төвд:

7. Улсын бүртгэлд бүртгэгдээгүй 54 трактор, 2 өөрөө явагч ачигч машины худалдах-худалдан авах баримт, техникийн үзүүлэлт, гаалийн баримт, татвар, техникийн хяналтын үзлэгийг шалгаж, шаардлага хангасан техник хэрэгслийг зээлдэгчийн нэр дээр бүртгэн, улсын дугаар, гэрчилгээ олгох ажлыг банкуудтай хамтран зохион байгуулах.

---oOo---



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2026 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/82

Баруун-Урт сум

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/175 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Шинэ хоршоо хөдөлгөөн"-д олгосон зээл, эргэн төлөлт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Татварын газар, Байгаль орчны газар, Автотээврийн газарт тус тус хүргүүлж ажиллахыг ахлах аудитор (Н.Болдбаатар)-д үүрэг болгосугай.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн ЗДТГ-ын Бүс орон нутгийн хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Г.Мөнхзаяа), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Ариунжаргал), Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Ц.Мөнхчимэг), Татварын газрын дарга (Д.Мөнхбаяр), Байгаль орчны газрын дарга (О.Батсайхан), Автотээврийн газрын дарга (Ө.Төгсжаргал) нарт хариуцуулсугай.

5. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (Н.Болдбаатар), аудитор (Э.Алтансүх), аудитор (Б.Ганцэцэг) нарт үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг аудитын менежер (М.Нарантуяа)-д даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Г.ДАВАА

D:\Бичиг хэрэг\2025\Тушаал\1. А тушаал-3 2025 хянуулах.docx

2226010159